



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 159

Улаанбаатар хот

Салбар бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.2.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Амар даатгал” ХХК нь Дархан-Уул аймаг, Дархан хот, 12 дугаар баг, 14-р байрны 3 тоот, Дорнод аймаг, Хэрлэн сум, 7 дугаар баг, “Талын хүлэг” ХХК-ийн байранд тус бүр нэг, нийт 2 салбар нээснийг бүртгэсүгэй.

2. Салбар бүртгэсэнтэй холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэхийг “Амар даатгал” ХХК /Т.Батзул/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

